



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.БАЯРСАЙХАН  
ТАНАА**

2013.05.03 № 06/103 УНБ-САД/2013/10/СА-ТБ

**Зарцуулагдаагүй хөрөнгийг төвлөрүүлэх  
тухай**

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын Хүний хөгжил сангийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн тайланд тусгагдсан ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хишиг хувиас 4,500.0 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

Ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хишиг хувийн 1.0 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 4,500.0 сая төгрөгийг 2013 оны 5 дугаар сарын 10-ний дотор Монгол банкн дахь ХХС-гийн 3402022 тоот дансанд төвлөрүүлж, хариуг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дарга Д.Баярсайхан, Ерөнхий нягтлан бодогч Ч.Эрдэнэбулган нарт хариуцуулав.

АУДИТОР



Р.ЦОЛМОН

070245